



“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ХХК-ИЙ  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  
Ц. ДАВААЦЭРЭН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.12.17 № 151

**ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТУХАЙ**

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ий 2012 он, 2013 оны эхний 9 сарын санхүүгийн зарим үйл ажиллагаанд эрсдлийн аудит хийхэд дараах зөрчил илэрлээ.

2013 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар техникийн хоцрогдолд орсон, технологийн шаардлага хангахгүйгээс ашиглах боломжгүй болсон 3-12 жил ашиглаагүй 2,414.9 сая төгрөгийн хөрөнгө байгаа бөгөөд дээрх ашиглалтгүй хөрөнгүүдийг ямар цех, удирдах ажилтны захиалгаар бэлтгэсэн талаарх нэгдсэн судалгааг аудитын явцад танилцагдаагүй байгаа зэрэг алдаа зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1.2-д “... аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар баталсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ыг үндэслэн дээр дурьдсан 2,414.9 сая төгрөгийн ашиглалтгүй хөрөнгийг захиалж, бэлтгэсэн албан тушаалтнуудад хариуцлага тооцох, мөн дээрх алдаа зөрчлийг зогсоож, цаашид давтан гаргахгүй ажиллахыг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ий МТХХ-ийн дарга Т.Бямбажаргалд үүрэг болгож албан шаардлага хүргүүлж байна.

Албан шаардлагын биелэлтийг 2014 оны 07 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг мэдэгдье.

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
АУДИТОР**

**Д.ГАНДОЛГОР**

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:  
/ МТХХ-ИЙН ДАРГА

**Т.БЯМБАЖАРГАЛ**



070400